

Малын шимэгчтэй тэмцэх менежмент

2025 оны 11 сарын 10

2025 оны 3-сард Канадын Махны чиглэлийн үхрийн судалгааны зөвлөл (BCRC) -өөс Малын шимэгчийн менежментийн талаарх вебинарыг зохион байгуулсан. Тус вебинарын үеэр Калгаригийн их сургуулийн Мал эмнэлэгийн факультетийн багш Др. Жон Гиллеард болон Мал эмнэлэг, хөдөө аж ахуйн эрүүл мэндийн үйлчилгээний Др. Карлинг Матежка нар үхэр сүргийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн малын гадна, дотор шимэгчтэй тэмцэх менежментийн шинжлэх ухаанд суурилсан стратегиудыг танилцуулсан юм.

Др.Гиллеард болон Др.Матежка нар, шимэгч хорхой нь жижиг хэмжээтэй ч үхрийн эрүүл мэнд, тарга тэвээрэг болон малчдын олох ашиг, орлого зэрэгт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг болохыг онцолсон. Дээрх хэлэлцүүлэг нь үхрийн аж ахуй эрхлэгчдэд шимэгч хорхойн эрсдэл болон тэсвэржилт буюу эмэнд дасал болох зэргийг ойлгуулахыг зорьсон.

Тэд, ердийн эмчилгээнээс илүү шимэгчид рүү чиглэсэн, тогтвортой арга руу хэрхэн шилжих талаар практик зөвлөмжүүдийг өгсөн ба ингэснээр үхрийн аж ахуй эрхлэгчид шимэгчдийг илүү үр дүнтэй хянах, үнэлэх, тэмцэх мэдлэгтэй болохын зэрэгцээ сүргийн эрүүл мэндийг хамгаалах, урт хугацааны эмчилгээний хувилбаруудыг хэрэгжүүлэх боломжтой юм.

Яагаад тэсвэржилт улам нэмэгдсээр байна вэ?

Энэ удаагийн вебинар “Яагаад тэсвэржилт улам нэмэгдсээр байна вэ? Бид үүнийг хэрхэн шийдэх вэ?” гэсэн асуултаар эхэлсэн юм. Др. Гиллиардын тайлбарласнаар, олон жилийн туршид шимэгчдийн эсрэг ивермектин зэрэг тарилгыг хэрэглэснээр шимэгчдийн тэсвэржилт улам нэмэгдсэн. Түүнчлэн “жил бүр мал сүргийг бүхэлд нь хамруулан эмчлэх” нь зохистой биш болсон хэмээн Др.Гиллиард онцолсон юм. Тэрээр хэлэхдээ “эхлээд эмчлэх” гэсэн хандлагаас илүүтэйгээр “эхлээд үнэлэх” гэсэн хандлага руу шилжих нь зохистой гэжээ. Өөрөөр хэлбэл, шимэгчид ямар түвшинд буйг урьдчилан шинжилж үнэлсний дараа зөв эмчилгээг хэрэгтэй үед хийх нь чухал гэсэн үг юм.

- **Эхлээд эмчлэх арга:** Шаардлагатай эсэхээс үл хамааран бүх малыг эмчлэх
- **Эхлээд шинжлэх арга:** Эмчилгээний хэрэгцээг тодорхойлохын тулд шинжилгээ хийж, мөн илүү чиглэсэн арга барилд хүрэхийн тулд эмчилгээний зөв хэлбэр, тунг ашиглах.

Шимэгчтэй тэмцэх менежментийн гурван чухал арга

Үхрийн аж ахуй эрхлэгчдийн хувьд шимэгч хорхойн хяналт нь хамгийн төвөгтэй асуудлуудын нэг байдаг.

Оношлогооны арга хязгаарлагдмал, ажиллагаа нэг бүр нь өөр байдаг тул сүрэг дэх шимэгчид, тэдгээрийн үзүүлж буй нөлөөг үнэлэхэд хэцүү байж болно.

Иймээс малын эмчтэй хамтран эмчилгээний төлөвлөгөө боловсруулж ажиллах нь чухал юм.

Др.Гиллиард, үхрийн аж ахуй эрхлэгчид шимэгчидтэй үр дүнтэй тэмцэх менежментдээ 3 үндсэн аргыг хэрэглэж болохыг онцлон тэмдэглэв:

1. Бэлчээрийн менежмент

Бэлчээрийн стратеги нь мал шимэгчдэд нэрвэгдэх эрсдэлийг бууруулан эмэнд тэсвэртэй болохыг удаашруулснаар шимэгчийн эсрэг эмчилгээний үр нөлөөг хадгалж, малын эрүүл мэндийг үрт хугацаагаар сайжруулахад тусалдаг. Бэлчээрийг сэлгэн, эрсдэл өндөртэй бэлчээрээс зайлсхийж эм хэрэглэхгүйгээр дотор шимэгчийн тоог бууруулах боломжтой.


1. Шимэгчийн тоог хянах

Малын баасан дахь өндөгний тоо болон бусад оношилгооны аргууд нь хэзээ болон эмчилгээ хийх шаардлагатай эсэхийг малчдад мэдэх боломжийг олгодог бөгөөд зардал болон тэсвэржилтийн эрсдлийг бууруулдаг.

2. Зорилтот/чиглэсэн малыг хорхойгүйжүүлэх

Хорхойгүйжүүлэх бэлдмэлийг байнга бус, эрсдэлд үндэслэн хэрэглэх нь эмчилгээний хувилбаруудыг хадгалахад тусалдаг. Зөв тунг хэрэглэх, зарим малыг эмчлэхгүй орхих зэрэг аргууд нь тэсвэржилтийг удаашруулж, хорхойгүйжүүлэх бэлдмэлүүдийг удаан хугацаанд үр дүнтэй болгодог.

График 1. Шимэгчээс сэргийлэх бэлчээрийн менежмент

 <p>Даац нь хэтэрсэн, малын тоо толгой олширсон бэлчээр үхрийн шимэгчийн тоо, халдварыг нэмэгдүүлдэг.</p>	<ul style="list-style-type: none">• Малыг олноор нь нэг дор бэлчээвэл малын баас ихээр хуримтлагдаж, шимэгчийн халдварыг нэмэгдүүлнэ.• Бэлчээрийн даацыг хэтрүүлэх нь (1) мал баастай газарт идээшлэн (2) халдварлуулах чадвартай авгалдайн дийлэнх нь байрладаг газарт ойрхон богино өвсийг иддэг.• Бэлчээрийг амрааж, сэлгэж байхгүй бол үхэр байнгын эзэн
--	--

	<p>болж халдварын мөчлөг зогсохгүй.</p>
<p>Бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх нь шимэгчийн тоог бууруулж, мал бэлчээрт халдварлах эрсдэлийг бууруулна</p>  	<ul style="list-style-type: none"> • Малын тоог зохистой хэмжээнд барьснаар баас хуримтлагдахыг хязгаарлан шимэгчийн халдварыг бууруулдаг. • Бэлчээрийг хангалттай амраах нь шимэгчийн тоог бууруулан үхрийг авгалдайгаар халдварлах боломжгүй болгож халдварын мөчлөгийг тасалдуулдаг.

Малын гадна, дотор шимэгчтэй тэмцэх зорилтот менежмент

Др.Гиллиард, Др. Матейка нар хоёулаа, үхэрт шимэгчдийн үзүүлэх нөлөөг онцолж, шимэгчид үхрийн ашиг шим, үржлийн ажлын үр дүнг хэрхэн чимээгүйхэн бууруулж, малчдын орлогыг багасгадаг талаар онцолсон юм.

Дотор шимэгчидтэй тэмцэх зорилтот менежмент

Др.Матежка, дотор шимэгчдийг шууд харж танихад хэцүү боловч эдгээр нь махны үхэрт гаднах шимэгчдээс дутуугүй аюул учруулдаг тул тэдгээрийг хянахын тулд шинжилгээ хийж, эмчилгээ хийх хугацаа, хувилбарыг оновчтой сонгох талаар ярилцав.

Гадна шимэгчидтэй тэмцэх зорилтот менежмент

Др.Матежка, эмчилгээний хугацаа болон эмчилгээ тохирсон байдал нь шимэгчийн мөчлөгийг таслан зогсоож, шимэгчид эмэнд тэсвэржихээс сэргийлэх үндэс болдог тул махны

үхэр маллагчид шимэгчдийг хэрхэн таних, зөвхөн шаардлагатай үед эмчлээд, дараа нь хянах нь чухал болохыг тайлбарлав.

График 2. Үхрийг хорхойгүйжүүлэх бэлдмэлд тэсвэржилт үүсэх нь

1. Хорхойгүйжүүлэх бэлдмэл олгохоос өмнө	2. Үр дүнтэй эмчилгээ	3. Хагас үр дүнтэй эмчилгээ	4. Эмчилгээ амжилтгүй болох
			
<p>Эхэндээ хорхойн популяцийн зарим нь хорхойгүйжүүлэх бэлдмэлд мэдрэг (цагаан өнгөтэй), маш цөөн хорхой тэсвэртэй (улаан өнгөтэй) байдаг.</p>	<p>Хорхойгүйжүүлэх үед эмэнд мэдрэг хорхойнууд устаж эмэнд тэсвэртэй болсон цөөн хорхой үлдэж, үржинэ.</p>	<p>Хэд хэдэн эмчилгээний явцад тэсвэртэй хорхойн тоо аажмаар нэмэгдэж, үхэр болон бэлчээрийг халдварлуулна.</p>	<p>Эцэст нь эмэнд тэсвэртэй болсон хорхойн тоо нэмэгдэж, эмчилгээ үр дүнгүй болох нөхцөл үүснэ.</p>
<p>Эх сурвалж: Матилде Томаселли, Др. Жон Гиллеард, Калгарийн их сургуулиас сэдэвлэв. BCRC.</p>			

Шимэгч хорхойтой тэмцэх менежментийн 8 зөвлөмж

Др.Матейка, шимэгчтэх өвчний эмчилгээг үр дүнтэй болгож чадах **мэргэжлийн 8 зөвлөгөөг** хуваалцсан юм. Дараах алхмуудыг дагаж мөрдсөнөөр мал сүргийн эрүүл мэндийг хамгаалж, үйлдвэрлэлийг сайжруулж, эмэнд тэсвэртэй болохыг удаашруулна гэжээ.

1. Малын амьдын жинд үндэслэн эмийн тунг тохируулан хэрэглэх.
2. Цантсан, нойтон эсвэл баасаар бохирдсон үстэй хэсэгт эм хэрэглэхгүй байх.
3. Шаардлагагүй үед эм хэрэглэхгүй байх, зөвхөн шимэгч илэрсэн үед л хэрэглэх.
4. Боломжтой бол шавжийн эсрэг үйлчилгээтэй өөр өөр ангиллын эмийг ээлжлэн хэрэглэх.
5. Малын тоо толгойг хэт өсгөх, бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглахаас зайлсхийх.
6. Шинэ малыг тусгаарлан ажиглаж, сүрэгт нийлүүлэхээс өмнө шимэгч илрүүлэх үзлэг эсвэл шинжилгээ хийх.

7. Бэлчээр сэлгэх стратегийг анхаарч үзэх.
8. Шимэгч хорхойгоор өвчлөмтгий, ихээр ялгаруулж буй малыг заазлах.

Канадын Махны чиглэлийн үхрийн судалгааны зөвлөл (BCRC)-ийн зөвшөөрөлтэй орчуулан нийтлэв.